



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/153

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, Засаг даргын удирдлагын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Өсвөрийн хөгжимчдийн "Уран эгшиг" улсын VIII уралдаанд оролцох үндэсний хөгжмийн "Хишигтэн" хамтлагт замын зардлын дэмжлэг үзүүлсүгэй.
- 2.Дэмжлэгт шаардагдах 2,500,000 (хоёр сая таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.
- 3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР